Гантогтохын Орхон

Ардын Боловсролд Ард Иргэдийн Оролцоог Нэмэгдүүлэх нь

Сассексийн Их Сургууль
Англи улс, Брайтон хот

2008

Удиртгал

'Ардын боловсрол' хэмээх ухагдахууныг Монгол хэлний үгийн оноч талаас нь дэлгэрүүлэн харвал, 'ардчилал' гэдэг үгийн үндэс 'ард' тул, энэ нь ардчилсан

боловсрол, ард иргэд боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулах гэсэн давхар утгыг илтгэж байна. Харин манай өнөөдрийн боловсрол ийм хэв шинжийг хадгалсан жинхэнэ 'ардын боловсрол' уу, аль захиргаадалтын шинж бүхий 'засгийн боловсрол' уу гэдэгт энэхүү судалгаа анхаарлаа хандуулах юм.

Дэлхийн хөгжингүй хийгээд хөгжин буй олон орнуудад сүүлийн жилүүдэд боловсролын тогтолцооны төрөөс хэт хамааралтай төвлөрлийг задалж, боловсролын байгууллагын өөрөө удирдах системийг дэмжиснээр, ард иргэдэд үр хүүхдийнхээ боловсрол хүмүүжилд санаа тавин, сургалтын чанар, сургуулийн үйл ажиллагааг сайжруулахад дуу хоолойгоо өргөх боломжийг олгож, ардын боловсрол тэр чинээгээр хөгжих хандлагатай байна.

Олонхи улсуудын туршлагаас харахад төвлөрлийг өөрийн орны онцлогтой нийцүүлэн зохистойгоор сааруулж, сургуулийн удирдалгын төвшинд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг төрийн бодлогоор зохицуулан шийдсэн байна. Манайд ийм системийг бий болгох оролдлого сургуулийн зөвлөлийг сургууль бүр дээр байгуулснаар гарсан боловч, энэ нь төдийлөн амжилтгүй байгаа нь ард иргэдэд хангалттай орон зайг бодлогоор тавьж өгөөгүй, боловсролын байгууллагад буй улс төржсөн нөлөө, ард иргэдэд эрхийг нь ойлгуулах мэдээлэл хомс байгаатай холбоотой байна. Судалгаанд Англи улсын сургуулийн удирдах систем хэрхин ажилдгийг жишээ болгон оруулж ийм системийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийг шинжилсэн.

Энэхүү судалгаа нь 3 үндсэн бүлэгтэй: Нэгд, төвлөрлийг сааруулж, боловсролд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол, эерэг хийгээд сөрөг талын судалгаа; Хоёрт, Английн сургуулийн удирдах системийг ажиглаж энэ системийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн хүчин зүйлсийг тодотгосон; Гуравт, манай орны боловсролын орчин, төвлөрлийг задалсан байдлын талаар судалж, ард иргэдийн оролцоо бүхий сургуулийн өөрөө удирдах системийг цаашид хөгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл манай оронд хэрхин бүрдсэн, эерэг

ба сөрөг талууд, гарч болох саад, цаашид сөрөг талуудыг хэрхин шийдвэрлэж болох талаарх санал зэрэг хэсгүүдтэй байна.

Нүүдэлчин ахуйгаас улбаатай гэрийн сургалт хүмүүжил нь бурхны шашны гүн боловсролоор баяжиж, улмаар Монгол төрт ёсны тэнхимийн боловсролоор хөгжиж, цаашлаад зүүн Европын соёл шингэсэн албан боловсрол дэлгэрсэн манай орны баялаг уламжлал бүхий энэ хөрсөнд шинэ эрин үеийн 'ардчилсан боловсрол'-ийн үрийг тарихад энэхүү судалгаа хувь нэмрээ оруулна гэдэгт итгэнэм.

1. Төвлөрлийг сааруулж, боловсролд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдол

Боловсролын хөгжилд төрийн оролцоо багасч, ард иргэдийн оролцоо ихсэхийн хирээр боловсрол хөгжиж ардчилсан шинжтэй болдог гэж боловсролын социолологит үздэг (Ичинхорлоо 2007). Төрийн эрх мэдэл, үүрэг хариуцлага, албан тушаалтны эрхийн хувиарлалтыг орон нутаг, сум дүүрэг, цаашлаад сургуулийн төвшинд шилжүүлж, боловсролын тогтолцооны төрөөс хэт хамааралтай төвлөрлийг задалдаг. Ийнхүү задалснаар, боловсролын байгууллагын үйл ажиллагаа хэрэглэгч болсон ард иргэдтэйгээ улам ойртож, ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй, орон нутгийнхаа онцлог хэрэгцээ шаардлагыг хангасан шинжтэй болдог байна (Мклийн, Кинг 1999). Энэ үзэл санаан дээр тулгуурлан дэлхийн олон орон тухайлбал Англи, Австрали, Канад, Гонконг, Шинэ Зеланд, Португал, Америк, Өмнөд Африк зэрэг улсууд төвлөрлөрсөн бус системийг амжилттайгаар хэрэгжүүлсэн анхны орнууд болжээ.

Төвлөрлийг задлах арга нь улс төрийн, захиргааны, санхүүгийн, зах зээлийн гэсэн хэлбэрүүдтэй. Төвлөрлийг задалсан арга туршлагууд нь улс бүрт өөр өөр байгаач үндсэн зорилго нь боловсролыг ардачлах, сургуулийг сайжруулах нэг чиг хандлагатай. Жишээ нь, Өмнөд Африкт сургуулийг ардачлах гэсэн баримтлал илүү тодоор ажиглагдаж сургуулийн удирдах зөвлөлийг сургуулийн ардчилсан засаглал хэлбэрээр хөгжүүлсэн байхад, Англид зах зээлийн хэрэглэгчдээ ойр байх

зарчмыг илүүд баримтлан, боловсролын хэрэглэгч болсон ард иргэд сургуулийн засаглал дахь өрсдийн эрх мэдлээр дамжуулан хүүхдүүддээ чанартай боловсрол олгоход анхаарал хяналтаа тавьж боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулж байна. Орон нутгийн удирдлага, сургууль, ард иргэд гэсэн гурвалсан холбоо нь ил тод, хариуцлагын тогтолцоог бий болгодог.

1990 оны Жомтиенд болсон хурлаас аваад 2000 оны Дакар хүртэлх боловсролын томоохон олон улсын чуулга уулзалтуудад боловсролыг хөгжүүлж сургуулийн засаглалыг төгөлдөржүүлэхэд ард иргэдийн оролцоо онцгой үүрэгтэйг чухалчлан авч үзсэн. Түүнчлэн ард иргэдийн оролцоог сургуулийн засаглалд нэмэгдүүлэх нь төвлөрсөн бус системийг жинхэнэ утгаар хөгжүүлэх гарц хэмээн үзэх болсон (Манор 1999). Гэвч ард иргэдийн оролцоог шийдвэр гаргах төвшинд нэмэгдүүлэх нь сайн үр дагавартай ч олон бэрхшээлтэй асуудлуудтай тулгардаг байна. Доорх хүснэгтэд сайн талууд болон бэрхшээлтэй талуудыг үзүүллээ.

Ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн сайн талууд	**Ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн бэрхшээлтэй талууд**
Сургуульд нэмэлт нөөц хуримтлагдах Сургуулийн үйл ажиллагаа илүү биеэ даасан, хариуцлагатай, үр нөлөөтэй болох Хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурласан сургалтын хөтөлбөр Сургуулиа сонгох олон сонголт Сургалтын амжилт болон сургуульд хамрагдахад илүү ахицтай	Санхүүгийн болон эд материалын хандив ард иргэдээс орж ирэх нь голцуу бага Сургуулийн хариуцлага хүлээх механизм нь ард иргэдэд гэхээсээ илүүтэй төр лүү дээшээ хандлагатай Төрийн хариуцлага багасч байгаач эрх мэдлээ шилжүүлэх нь бага Эмзэг бүлгийн иргэдтэй холбоотой ачаалал нэмэгдэх

Багш нарын ур чадвар нэмэгдэх Сургалтын чанар дээшлэх Ард иргэдийн дунд илүү ардчилсан үзэл санаа төлөвших Ард иргэд сургуулийн удирдлагад ажилласнаар өөрсдийн чадварыг давхар нэмэгдүүлэх Боловсролын хэт төвлөрлийг багасгаж бие даах чадварыг нэмэгдүүлэх	Ард иргэдийн байнгын идэвхтэй оролцоо дутагдалтай Сургуулийн захирал улс төрийн нөлөөлөлд орох хандлагатай Сургуулийн удирдлагад орох иргэдийг ажил мэргэжил, үндэс угсаа, хэл соёл, шашин шүтлэг, арьс өнгөөр ялгаварлах хандлага Сургуулийн удирдлагын эрх мэдэл үүрэг хариуцлага тодорхойгүй бүрхэг байдал Сургуулийн удирлагад орсон ард иргэдийн төлөөлөл нь нэг хоёр хүний давамгайлалтай байхаар тэнцвэргүй зохион байгуулах Багш нар эцэг эхийн төлөөлөл сургуулийн удирдалгад ихээр байхаас зайлсхийх хандлага Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт дутуу дулимагаас чадваргүй төлөөлөл сургуулийн ажиллагаанд муугаар нөлөөлөх

эх материал: (Дунне 2007: 26, 27)

Ард иргэд оролцох орон зай боловсролын системд байна уу, түүнийг засгийн газрын бодолгоор бий болгож чадаж уу гэдэг их чухал (Корнвол 2002). Корнволийн үзэснээр тийм орон зайг бий болгох хоёр хэлбэр байдаг. Нэг нь орон зайг ард иргэд өөрсдөө олж хараад, холбоо иргэний нийгмийн байгууллага өөрсдийн санаачлагаар

байгуулж ажиллах, нөгөө нь төрийн бодлогоор орон зайг нь бий болгож тусгай систем гаргаж өгөх аж. Эхнийхэд нь эцэг эх багш нарийн холбоо зэрэг байгууллагууд орж болно харин сүүлийнх нь улсаас боловсролын хуулиар зааж өгсөн тодорхой эрх бүхий, ард иргэдийн оролцоотой сургуулийн удирдах зөвлөл эсвэл сургуулийн засаглал байх юм. Ийм систем хэрхин ажилладаг талаар ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс, Английн сургуулийн засаглалын системийг жишээ болгон дараагийн булэгт үзүүлж, улмаар ийм системийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн хүчин зүйлсийг шинжилнэ.

2. Английн Сургуулийн Засаглалын Систем

1988 онд Английн засгийн газраас орон нутагт хувиарладаг байсан боловсролын төсвийг сургууль сургуульд нь шууд олгох болсноор сургууль төсвийн мөнгийг илүү үр өгөөжтэй ашиглах, бие даан хөгжих шаардлагатай уялдан сургуулийн засаглалын систем бий болжээ. Сургуулийн үйл ажиллагааг дотор нь ажиллаж байгаа хүмүүс болон хэрэглэгч нь илүүтэй сайн мэдэж, шийдвэрээ өөрсдөө гаргаж байх нь улсын, орон нутгийн хэн нэгэн албан тушаалтан сургуулийн талаар шийдвэр гаргахаас илүү үр дүнтэй байх нь илт (Буш 1999).

Сургуулийн засаглал нь тодорхой хуулийн хүрээнд сургуулийн стандарт, санхүүгийн менежмент, сургалтын явц, үзүүлэлтийг сайжруулах чиглэлийг хариуцан, хамтын хүчинд тулгуурлан ажилладаг сургуулийг удирдах баг юм. Энэ нь сайн дурын ажил учраас ихэнх засаглалын гишүүд нь нийгмийн идэвхтэй, оршин суугаа нутгийнхаа боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулах хүсэлтэй хүмүүс байдаг бөгөөд Англи улс даяар 300 000 сургуулийн засаглалын гишүүд идэвхтэй ажиллаж байна (NGA 2006).

Сургуулийн засаглалын гишүүдийн гол үүрэг хариуцлага нь дараах чиглэлтэй: Нэгд, сургуулийн зорилго, сургуулийг сайжруулах үндсэн төлөвлөгөөг гаргаж, байгаа нөөц бололцоогоо мэдэрч ажиллах зэргээр сургуулийн хэтийн хөгжлийг тодорхойлох; Хоёрт, сургуулийн санхүү, үйл ажиллагаа, үзүүлэлтэд хяналт тавьж сургуулийн захирлын алдаа дутагдалд шүүмжлэлтэй хандаж, ойрын нөхөрсөг

зөвлөгч байх; Гуравт, сургууль нь сургалтын байгууллагын хэрэглэгч болсон сурагч эцэг эхчүүд, ард иргэдийн өмнө хариуцлагатай, ил тод, үр нөлөөтэй ажиллаж байгааг баталгаажуулагч байх гэсэн үндсэн гурван үүрэгтэй байна.

Сургуулийн засаглал нь эцэг эх, ард иргэд, багш ажилчдаас сонгогдсон төлөөлөл болон сургуулийн захирал, дүүргийн боловсролын газрын томилсон мэргэжилтэн нарын 9-20 гишүүдээс бүрдэнэ (DCFS 2006). Тэд сургуулийн засаг даргыг дотроосоо сонгож, сургуулийн засаглалын хуулинд заасан үйл ажиллагаагаа явуулах загваруудаас өөрийн сургуулийн онцлогт тохирсон загварыг сонгож, түүнийгээ эрх зүйн үндэс болгон ажилладаг байна. Тэд сард хоёроос доошгүй хуралдаж, явцтай танилцаж, зарим үед хичээлд сууж, дотоод ажилтай танилцан, ажиглалтаа тайлагнах маягаар ажлаа явуулдаг байна.

Их Британий засгийн газраас 'Өргөжүүлсэн сургууль' гэсэн шинэ хөтөлбөрийг танилцуулж байгаа бөгөөд энэ хөтөлбөрийн гол санаа нь сургууль тухайн оршин байгаа газрынхаа ард иргэд, байгууллагуудтай илүү нээлттэй хамтран ашигтай ажиллах явдлыг дэмжиж нэмэлт төсвийг улсаас сургуулиудад олгох болсон байна (DCFS 2006). Энэ хөтөлбөрийн дагуу, сургуулийн байрыг тухайн дүүргийн иргэд, эцэг эхчүүд сурч боловсрохдоо чөлөөтэй ашиглаж болох хэлбэрт шилжүүлж, дүүргийн аж ахуйн нэгжүүдтэй хамтарч болох бүхийл хэлбэрийг эрэлхийлэн ажилласнаар сургууль тухайн орчныхоо боловсролын нээлттэй төв нь байж ард иргэд, сургууль, төр засгийн чандмалсан холбоог бэхжүүлэх зорилготой ажээ.

Сургуулийн засаглалын систем амжилттай хэрэгжих нь дараах үндсэн нөхцлүүд хэрхин бүрдсэнтэй хобоотой мэт ажиглагдаж байна.

- Сургуулийн засаглал нь хуулиар тогтоосон санхүүгийн болон шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Жишээ нь, засаглалын гишүүдийн хурлаар сургуулийн захирлыг сонгон шалгаруулж авдаг

- Засаглалын системийг хэрэгжүүлэх ойлгомжтой хуулийн заалт, ажиллах жишиг загвар, хариуцлагын тогтолцоог бодлогоор тодорхойсон.

- Сайн дурын ажилд идэвхтэй ханддаг нийгмийн бүтээлч хандлага. Ард иргэдэд сургуулийн засаглалд чөлөөтэй нэрээ дэвшүүлж сонгогдож болох эрхийг олгож, энэ талаар хангалттай мэдээллийг ард иргэдэд хүргэсэн.

- Сургуулийн засаглалын гишүүдийг чадавхжуулах сургалт, мэдээлэл, сүлжээ зэргийг хангалттай бүрдүүлсэн

Сургуулийн засаглалын системийг Монгол оронд хөгжүүлэхэд, дээрх нөхцлүүд хэрхин бүрдсэн болохыг дараагийн бүлгүүдэд судална.

3. Монголын боловсролын хөгжилд ард иргэдийн оролцоо хир нээлттэй байна вэ?

3.1 Боловсролын системийн төвлөрлийг сааруулсан байдал

Ардчилалын үрээр боловсролын системийн шинэчлэлт 1990 оноос манай оронд тасралтгүй явагдаж байгаа бөгөөд үүний нэг илрэл нь боловсролын тогтолцооны төрөөс хэт хамааралтай төвлөрлийг задлах оролдлого юм. Дараах хүснэгт төвлөрөл макро, мезо, микро төвшинд хэрхин саарсныг үзүүлж байна.

1990 он хүртэлх төвлөрсөн тогтолцоо	**Төвлөрсөн бус тогтолцоо**
Боловсролын Яам бүх шийдвэрийг гаргадаг байсан. • Төсөв санхүү • Боловсон хүчин	1990ээд оны дунд үеэс Монголын боловсрол төвлөрсөн бус тогтолцоонд аажмаар шилжиж байна. Жишээ нь: • Боловсролын Яамны гол үүрэг нь улс даяар төрийн бодлого

• Сургалтын агуулга	тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдэх болсон (макро) • Орон нутгийн засаг даргын эрх үүрэг нэмэгдсэн: Сургуулийн захирлыг томилох болсон. Төсвийг захиран зарцуулах эрхийг орон нутагт шилжүүлж байсан ч, 2000 оноос эргээд төвлөрсөн төсөвт орсон. (мезо) • Сургуулийн удирдлага нь сургуулийн захирал тэргүүтэй захиргааны баг болон эцэг эх, сурагч, ард иргэд, багш нарын төлөөлөл бүхий сургуулийн зөвлөлөөс бүрдэх болсон.(микро) • Сургалтын агуулгын 25% хүртэлх хувьд орон нутгийн онцлог болон тухайн сургуулийн тусгай зорилттой нийцүүлсэн өөрсдийн хөтөлбөртэй болсон

эх материал: (Ичинхорлоо 2007)

Судлаач Стейнер Камси (2004) Монголын боловсролын системийн төвлөрлийг сааруулах явцыг ажиглаад, Боловсролын яамны 1992-2002 онуудад хийсэн төвлөрлийг сааруулах оролдлогууд амжилтгүй болж, улмаар 2002 оны боловсролын хуулиар тогтолцоог эргүүлэн төвлөрсөн тогтолцоонд оруулсан гээд, төвлөрлийг сааруулах ажлыг хэрхин 'монголчилсон' талаар бичжээ.

Монгол улсын 2006-2015 оны боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь: 'Боловсролын захиргаа мэргэжлийн удирдлагын тогтолцоог нэгж байгууллага, орон нутаг, үндэсний төвшинд шийдвэр гаргах, эрх мэдлийн төвлөрлийн сааруулалт, шилжүүлэлт, сийрэгжүүлэлтийн оновчтой хувиарлалттай, эрх мэдэл, үүрэг хариуцлага, ёс зүйн зохистой шүтэлцээтэй, ил тод хяналттай болгон шинэчилж, байгууллагын хөгжлийг дэмжиж, сургуульд суурилсан удирдлагыг хөгжүүлэх' гэжээ. Үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд сургуульд суурилсан удирдлагыг хөгжүүлэх, боловсролын эрэлт хэрэгцээний өсөлтийг хангаж оролцогч талуудын сонирхлыг зохицуулах гэсэн заалтууд орсон байгаа нь авууштай. Энэ нь цаашид манай улс төвлөрлийг сааруулах чиг хандлагыг баримтлахыг тодорхойлж байгаа ч, хэрхин хэрэгжүүлэх талаарх бодолгын чанартай тодорхой ажлуудыг мастер төлөвлөгөөнд нарийвчлан тусгаагүй нь ажиглагдаж байна. Төвлөрлийг сааруулахын зорилгыг сургуулийн өөрөө удирдах менежментийн тал дээр голчлон чиглүүлж, төвлөрлийг сааруулахын гол ач холбогдол болсон ард нийтийн оролцоог хөгжүүлэх талыг хэт орхигдуулсан байна. Төвлөрлийн сааруулалт сургуулийн төвшинд хэрхин хэрэгжиж байгааг батагтахийн тулд хэд хэдэн сургуулийн захирлаас ярилцлага авч судалгаа явуулсан ба энэхүү судалгааны ажиглалтуудыг дараах хэсэгт хэлэлцэнэ.

3.2 Судалгааны ажиглалтууд

Сургуулийн зөвлөлийн үүрэг хариуцлагын тухай эхний асуултын хариултаас харвал сургуулийн зөвлөл жилд нэгээс хоёр удаа хуралдаж, сургуулийн жилийн ажлыг дүгнэн хэлэлцэж, ирэх жилийн төлөвлөгөөг баталж, сонгон суралцах ангийн төлбөрийг тогтоон үндсэндээ зөвлөх үүргийг гүйцэтгэдэг байна. Сургуулийн зөвлөлдөө жирийн ард нийтээс сонгогдсон төлөөлөгч гэхээсээ илүүтэй нэр хүнд бүхий хүмүүсийг байлгах сонирхолтой байгаа нь сургуулийн зөвлөл бэлэг тэмдгийн чанартай зөвлөл болох нь ажиглагдаж байна.

Сургуулийн захирал болон багш ажилчдыг ажилд авах талаар асуусан дараагийн асуултын хариултуудаас харахад сургуулийн захирлыг аймаг дүүргийн засаг дарга

боловсролын газраас санал болгосон нэр дэвшигч нараас сонгож томилдог. Харин багш ажилчдыг сургуулийн захиргаа сонгон шалгаруулж ажилд авдаг байна. Үүнээс үзвэл захирлын томилгоо улс төрийн нөлөөнд автаж болохуйц харагдаж байна.

Сургуулийг хяналт шалгалт ямар байдалтайг асуусан дараачийн асуултын хариултаас үзэхэд сургуулийг улс, хот, аймаг, дүүргийн боловсролын газраас графикаар шалгадаг. Олон нийтэд сургуулийн үйл ажиллагааг хянах орон зай байхгүй, эцэг эхийн хорооны оролцоо энэ тал дээр дулимаг байгаа нь ажиглагдаж байна.

Сүүлийн асуулт төвлөрлийн сааруулалтыг хир мэдэрч байна гэсэн асуултад, санхүү төсөв л төвлөрсөн хэлбэрт байгаа харин удирдлага зохион байгуулалт хүний нөөц гээд бүх асуудлыг сургууль өөрөө шийддэг болсон. Дүүргийн боловсролын газартайгаа ойр ажилласнаар урьдын хүнд суртал багассан. Цогцолбор сургууль байгуулагдсанаар сургуулиуд үйл ажиллагаагаа нэгтгэж нэг удирдлага зохион байгуулалттай болсон зэргийг дурдсан. Үүнээс үзэхэд төвлөрлийг сааруулалт нь сургуулиуд бие даах өөрөө удирдах менежментийг нэвтрүүлэхэд түлхэц болсон байна. Судалгааг дүгнэхэд төвлөрлийн сааруулалт сургуулийн удирдлагын төвшинд тодорхой хэмжээгээр хэрэгжиж байгаа ч ард иргэд сургуулийн удирдлага хяналтад оролцох орон зай бүрэлдээгүй байна.

3.3 Ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой нөхцөл байдлын эерэг, сөрөг талын шинжилгээ

Эхлээд ард нийтийн оролцоот боловсролын системийг манай оронд нэвтрүүлэхэд тааламжит орчин нөхцөл хэрхин бүрдсэнийг үзье.

Манай орон дэлхий дахины боловсролын үндсэн зорилго болсон бичиг үсэгт тайлагдах, бүх нийтэд бага дунд боловсролыг олгох, сургуульд тэгш эрхтэйгээр элсүүлэх зэрэг зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж буй орнуудын нэг бөгөөд

энэхүү боловсролын суурь амжилтыг бататган, цаашид боловсролд ард иргэдийг татан оролцуулснаар манай орны боловсрол ардчилсан чиг хандлагатай ил тод, хариуцлагатай чанартай болж ирэх юм.

Ард түмний боловсролд хандах хандлага нэн эртнээс эхтэй түүхэн уламжлалаар төлөвшсөн нь ардчилсан боловсрол хөгжих сайн хөрс болох нь илэрхий. 'Малчин ажилчин гэлтгүй Монгол аав ээжүүд бүгд бичиг үсэгт тайлагдсан, хүүхдээ сургуульд явуулах хүсэлтэй, идэвхтэй' гэж гадны судлаач цохон тэмдэглэжээ (Стейнэр Камси 2004). Манайд боловсрол тэр тусмаа бичиг үсгийн боловсрол Хүннүгийн үеэс эхтэй бөгөөд нүүдэлчин Монголчууд түүхийн туршид арав гаруй бичгийг зохион хэрэглэж, түүгээрээ олон ном шастир бичиж үлдээсэн нь боловсролын хир их суурьтай улс болохыг харуулна.
Боловсролын тогтолцооны төвлөрлийг сааруулах тодорхой туршлагыг сүүлийн 15 жил хуримтлуулсан тул цаашид төвлөрлийг зохистойгоор задлах арга барилтай болсон мөн хэтийн мастер төлөвлөгөөнд төвлөрлийг сааруулах зорилт орсон байгаа нь эерэг нөхцлийг бүрдүүлж байна.

Цаашлаад манай оронд сургуулийн дэд бүтэц харьцангуй сайн аймаг сум бүр сургууль дотуур байртай мэргэжлийн боловсон хүчин ямар нэг хэмжээгээр ажилладаг, мөн аймаг дүүрэг хотын боловсролын газрууд сургуулиудтай харьцангуй ойр ажиллах боломжтой байгаа зэрэг нь ард иргэд оролцсон боловсролыг хөгжүүлэхэд эерэг суурь нөхцөл болж байна.

Гэвч эерэг талуудын зэрэгцээ сөрөг хүчин зүйлүүд нилээдгүй байна. Нэгдүгээрт, ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гол арга болсон сургуулийн зөвлөлийн эрх үүрэг 'санал оруулагч, зөвлөх' төдийхнөөр хязгаарлагдаж, тодорхой эрх мэдлийн хувиарлалт тэдэнд олгогдоогүй байгаа нь боловсролын хуулийн 35 дугаар зүйлээс харагдаж байна. Английн сургуулийн засаглалын гишүүд ард нийт болон улсын хяналтанд хариуцлага хүлээж, захирлыг сонгон ажиллуулж, сургуулийн ажилтай сард хэд хэдэн удаа танилцаж, захирлын ажлыг ойроос хянах хуулиар олгогдсон санхүү, боловсон хүчин, хяналт, хариуцлагын тодорхой эрхүүдтэй байгаа нь энэ

системийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оновчтой бодлогод суурилсан хууль их чухал болохыг харуулж байна. Тэгэхээр манайд сургуулийн зөвлөл жинхэнэ утгаараа ажиллах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

1992-2002 оны төвлөрлийг сааруулах ажил амжилтгүй болсон нэг үндсэн шалтгааныг боловсролын байгууллагад оршиж байгаа улс төрийн нөлөө гэж судлаач нар үзжээ (Стейнэж Камси 2004). Ийм хандлага одоо ч байгаа учир нь засгийн эрхэнд байгаа намын засаг дарга тухайн сургуулийн захирлыг томилох эрхтэй байдаг. Хуучин тогтолцооноос улбаатай боловсролыг төр бүрэн хариуцдаг гэсэн ойлголт байсаар байгаа тул боловсролын байгууллагыг улс төрөөс ангид байлгахад саадтай байна.

Цаашлаад ард иргэд сургуулийн зөвлөлөөр дамжуулан боловсролд хувь нэмрээ оруулах эрхтэй гэдгийг ойлгуулах мэдээлэл сурталчилгаа хомс. Төвлөрсөн бус тогттолцоонд шилжиснээр боловсрол төрөөс хэт хамааралтай байхаа больж, боловсролын хэрэглэгч болсон ард иргэд өөрсдөө сургуулийн ажлыг хянаж, өөрчлөн шинэчлэх эрхтэй болсныг ард иргэдэд өргөн цар хүрээтэйгээр мэдээлээгүйгээс иргэд сургуулийн зөвлөлд идэвхтэй оролцож чадахгүй байна.

Англичуудын тухайн нийгэмдээ сайн дураар ажиллаж хувь нэмрээ оруулах нь нэр төрийн хэрэг бол манайд ийнхүү сайн дураар ажиллах сэтгэлгээ одоохондоо төлөвшсөн эсэх нь эргэлзээтэй юм. Хотын завгүй ажилладаг дунд насныхан, орлого, хүний нөөц багатай алслагдмал хөдөө нутагт суух ард иргэд сайн дураар сургуулийн ажилд цаг нараа зориулах нь бага харагдаж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд сургуультай үйл ажиллагаагаа холбосон нь бага, үндэсний хэмжээний эцэг эхийн холбоо, эрчтэй нөлөөтэй ажилладаг сургуулийн эцэг эхийн зөвлөл цөөн байгаа нь ард иргэдийн санаачлага сул байгааг харуулж байна.

Сургуулийн захирлыг хэрэглэгч болсон ард иргэд хянах орон зай байхгүйгээс, захиргаадалтын шинжтэй сургуулийн орчин үүсч, багш, эцэг эх сурагчдын дуу хоолой багасч, хамтын ажиллагаа хумигдах хандлага ажиглагдаж байна.

Эдгээр сөрөг талуудыг авч үзвэл, манайд сургуулийн засаглалын систем одоогоор амжилттай хэрэгжих нөхцөл хараахан бүрдээгүй байна.

Дүгнэлт

Сургуулийн удирдагын төвшинд ард иргэдийн оролцоог хэрхин нэмэгдүүлж байгааг Английн сургуулийн засаглалын системээр жишээлэн судалсан нь, манайд ийм системийг амжилттай нэвтрүүлэхэд шаардлагатай нөхцлүүд бүрдсэн эсэхийг тодотгоход тустай байлаа. Манайх Английн системтэй яг адил системийг хуулбарлан нэвтрүүлэхгүй нь лавтай. Харин ийм системийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн нөхцлийг танин мэдэх зорилгоор Английн туршлагыг жишин үзсэн билээ.

Судалгааг дүгнэн үзэхэд одоогоор манайд ард нийтийн оролцоо боловсролд төдийлөн нэвтрээгүй, үүнийг нэмэгдүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл хараахан бүрдээгүй харагдаж байна. Гэвч ард иргэдэд боловсролд илүүтэй оролцох нөхцлийг нь бүрдүүлсэн хуулийн эрэг орчинг бүрдүүлж, сургууль боловсролын хөгжилд хувь нэмрээ оруулах боломж ард иргэдэд нээлттэй болсныг олон нийтэд таниулж, сургуулийн зөвлөлийн чадамжийг дээшлүүлэх тасралтгүй сургалтыг явуулж, иргэний нийгмийн байгууллагууд сургуультай хамтран ажиллах боломжийг бодолгоор дэмжвэл, энэ систем манай орны боловсролд элэгтэй орчинд алсдаа бүрэн хэрэгжих үндэстэй байна.

Ном зүй

Allen, G and Martin, I. (1992). Education and community: The politics of practice. New York: Cassell.

Bush, T and Heystek, J. (2003). School governance in the New South Africa. Compare: A journal of comparative education, 33:2, 127-138

Bush,T and Gamage,D. (2001). Models of self-governance in schools: Australia and the United Kingdom. The International Journal of Education Management, 15,1,39.

Bush, T, Coleman, M and Glover, D. (1993). Managing Autonomous Schools: The Grant-Maintained Experience, Paul Chapman, London

Cornwall, A. (2002). Making spaces, changing places: situating participation in development. IDS working paper, N. 170, Brighton. IDS

Cornwall, A (2002a). Locating citizen participation, IDS Bulletin, 33, 2, 49-58

DCSF (2007). Extended schools: Building on experience, Nottingham: DCSF

Department for Education and Skills (2007). Governing the school of the future, available at: www.teachernet.gov.uk/ publications accessed on 20 March 2008

Dunne, M, Akyeampong, K and Humphreys, A. (2007). School Processes, Local Governance and Community participation: Understanding access. *Research monograph No 6*, Brighton: Centre for International education, University of Sussex

Gamage (1993). A review of community participation in school governance: An emerging culture in Australian education, *British Journal of Education Studies*, 41, 2, 134-149

Government of Mongolia (2006). Master Plan to Develop Education 2006-2015. available at: http://mecs.pmis.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=498&Itemid=2

Governor Support and Development Service (2008). The role and responsibilities of school governors, *IT resource,* accessed on 17 March 2008, available at: http://www.shropshire.gov.uk/governors.nsf/open/0396BCCA8134409280256C80004B6067

Ichinkhorloo, Sh.(2007). *Introduction to the Education Studies*. Ulaanbaatar: Soyombo printing

Manor, J. (1999). *The political economy of democratic decentralization.* Washington D.C: The World Bank

MECS (2007). Mongolian Education Law and regulations, Ulaanbaatar; Mongolia

NGA (National Governor's Association) (2006). Welcome to Governance, *Trigger Pack Series*-Issue 6 A Handbook for new school governors

Pellini, A. (2007). Decentralization policy in Campodia: Exploring community participation in the education sector. (academic dissertation) University of Tampere, Department of Education, Finland. available at: http://acta.uta.fi/pdf/978-951-44-6978-7.pdf accessed on 15 March 2008.

School Governance (Constitution) (England) Regulations 2007: SI 2007/957 available at: http://www3.hants.gov.uk/constitutionregs2007-2.pdf accessed on 1 April 2008.

Shagdar, Sh. (2003). *Mongolian education history,* Ulaanbaatar: Mongolia

Steiner-Khamsi, G (2007). Mongolia country case study, Country profile prepared for the Education for All Global Monitoring Report 2008, 2008/ED/EFA/MRT/PI/70, UNESCO

Steiner-Khamsi,G and Ines Stolpe. (2004). Decentralization and recentralization reform in Mongolia: tracing the swing of the pendulum, *Comparative Education*, 40, 1, Feb 2004

Sukhbaatar, G (1980). *Early Ancestors of Mongols,* Ulaanbaatar: Mongolia.